



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 486

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргаа”-г байгуулах 209 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1, 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сангийн Сайдын багцын улсын төсвийн хөрөнгөөр бий болсон 30 нэрийн, нийт 532,882,504.30 (таван зуун гучин хоёр сая найман зуун наян хоёр мянга таван зуун дөрвөн төгрөг гучин мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргааны дарга Ш.Лханчинжав нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн
486 дугаар тогтоолын хавсралт

Хилийн боомтын онцгой бүрэн эрхт захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэх
хөрөнгийн жагсаалт

№	Хөрөнгийн нэр	хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ (ам.доллар)	Хөрөнгийн үнэ (ам.доллар)
1. Тавилга, эд хогшил					
1	Хүндрүүлэгчтэй сейф	ш	1	1,184,900.00	1,184,900.00
2	BSB хөргүүр	ш	1	299,900.00	299,900.00
3	Баримтын шүүгээ	ш	1	789,900.00	789,900.00
4	Дарга сандал хар	ш	1	990,000.00	990,000.00
5	Халаагуур	ш	2	165,000.00	330,000.00
6	Хөргөгч beko	ш	1	1,199,990.00	1,199,990.00
7	Утасны аппарат	ш	1	130,000.00	130,000.00
8	Факсын аппарат	ш	1	330,000.00	330,000.00
9	Телевизор 65 инч rotenzo smart	ш	1	2,399,900.00	2,399,900.00
10	Кофены машин Крупс	ш	1	1,499,900.00	1,499,900.00
11	Печь	ш	1	299,990.00	299,990.00
	ДҮН		12		9,454,480.00
2. Тоног төхөөрөмж,					
12	Dell 20 inch se2018hl	ш	2	473,000.00	946,000.00
13	Dell E2420H 24 инч	ш	2	523,000.00	1,046,000.00
14	Dell E2420H 24инч дэлгэц	ш	3	607,107.60	1,821,322.80
15	Dell optiplex 3080 i5 8gb	ш	2	1,815,000.00	3,630,000.00
16	Dell optiplex3080 процессор	ш	3	1,760,000.00	5,280,000.00
17	Ipad pro 11inch	ш	3	3,359,920.00	10,079,760.00
18	Transcend 128gb SSD	ш	1	100,000.00	100,000.00
19	Өнгөт принтер epson l15150	ш	1	2,732,308.00	2,732,308.00
20	Зөврийн компьютер dell	ш	1	2,571,000.00	2,571,000.00
21	Принтер HP laserjet M130A	ш	1	565,908.00	565,908.00
22	Принтер өнгөт Epson l3119	ш	1	561,000.00	561,000.00
23	Өнгөт принтер L850	ш	1	1,430,000.00	1,430,000.00
24	Процессор dell optiplex 7080mt	ш	3	2,575,908.50	7,727,725.50
25	Таблет үзэг	ш	1	385,000.00	385,000.00
26	Таблет сарфейс про 7	ш	1	4,180,000.00	4,180,000.00
27	Цаас устгагч Deli	ш	1	480,000.00	480,000.00
28	Зөврийн компьютер dell 10	ш	1	3,052,000.00	3,052,000.00
	ДҮН		28		46,528,024.30
3. Тээврийн хэрэгсэл					
29	Ланд крузер LX200 саарал	ш	1	266,900,000.00	266,900,000.00
30	Ланд крузер LX200 хар	ш	1	210,000,000.00	210,000,000.00
	ДҮН		2		476,900,000.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		42 (дөчин хоёр)		532,882,504.30 (таван зуун гучин хоёр сая найман зуун наян хоёр мянга таван зуун дөрвөн төгрөг гучин мөнгө)